



МОНГОЛ УЛСЫН САЙД,
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амын бие бялдрын хөжлийн түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэх, сорилын төв байгуулах санхүүгийн тооцоолол хийх, сорилын цахим санг бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж удирдлага, хяналт, арга зүйгээр хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс /О.Баасан/-т даалгасугай.
2. Ажлын хэсгийн гишүүдийг нэгдүгээр, ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, ажлын удирдамжийг гуравдугаар, ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын үүрэг гүйцэтгэгч /О.Баттулга/-т үүрэг болгосугай.

Монгол улсын сайд, Олимп,
нийтийн биеийн тамир, спортын
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ

000009



Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир,
спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 01 дүгээр
сарын 17 - ны өдрийн 22 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт

**ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛЫН СТАНДАРТЫГ
ШИНЭЧЛЭХ, СОРИЛЫН ТӨВ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга

О.Баасан

Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын
бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Гишүүд:

М.Болд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх /тохиролцсоноор/

С.Мөнх-Эрдэнэ

Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого
төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

Б.Лхагваням

Биеийн тамир, спортын улсын хорооны Гадаад харилцаа,
мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Болдмаа

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Спорт, нийтийн
биеийн тамирын хэлтсийн дарга

Ш.Бат-Эрдэнэ

Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн Биеийн
тамирын эмчилгээ арга зүйн тэнхимийн эрхлэгч

Г.Бүрэнбилэг

“Эрүүл Монгол хүн” хөдөлгөөний зохицуулагч

Нарийн бичгийн дарга:

Н.Батмагнай

Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын
бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Ганцэцэг

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны
ажлын албаны мэргэжилтэн

--ooOOoo--

Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир,
спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 01 дүгээр
сарын 01 - ны өдрийн 4/22 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫНТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Хийх хугацаа	Хариуцах эзэн
1.	Бие бялдрын түвшин тогтоох стандарт, Сорилын цахим сангийн төсөлд дүн шинжилгээ, нэмэлт боловсруулалт хийж шинэчлэх ажлын хэсгийн удирдамж, тушаал боловсруулах.	2023 I/17	Нарийн бичгийн дарга нар
2.	“Бие бялдрын түвшин тогтоох стандарт”-ийг боловсруулахад шаардагдах мэдээллийг цуглуулах;	2023 I/25-II/15	Ажлын хэсгийн гишүүд
3.	Стандартад тусгагдах баримт бичгийн боловсруулалт хийж ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэх;	2023 I/25	С.Мөнх-Эрдэнэ
4.	Сорил авах арга, аргачлалын талаар харьцуулсан судалгаа хийж, хэлэлцүүлэх;	2023 I/25	Ажлын хэсэг
5.	Бие бялдрын түвшинг тодорхойлох, хэмжилт хийх арга аргачлалыг боловсруулах;	2023 I/25-III/15	Ажлын хэсэг
6.	Сорилын программын өгөгдлийн сангийн архитектурын зураглалын боловсруулах;	2023 I/25-III/31	Б. Лхагваням Ажлын хэсэг
7.	Боловсруулсан процессын зураглал болон өгөгдлийн сангийн архитектурын зураглалын цахим сангийн хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх;	2023 IV/3-IV/28	Б. Лхагваням Ажлын хэсэг
8.	Сорилын цахим санг бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэх;	2023 III/15-V/1	Б. Лхагваням Ажлын хэсэг
9.	БНСУ – ийн “Иргэдийн эрүүл мэнд-100” сорил үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах	2023 II/13-17	О.Баасан
10.	Сорилын төвийн өрөө тасалгаа, талбайн зай хэмжээг тодорхойлох	2023 III/1-31	Ажлын хэсэг
11.	Сорилын төвд нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эд материалын тоо ширхэг, үзүүлэлт зах зээлийн үнийн судалгааг гаргах.	2023 III/1-31	Ажлын хэсэг
12.	Сорилын төвийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлох	2023 III/1-31	Ажлын хэсэг
13.	Сорилын төв байгуулах орон нутгийн биеийн тамир спортын хороо /газар/ -г сонгох.	2023 IV/12	Ажлын хэсгийн гишүүд
14.	Хүний биометрийн үзүүлэлт болон бие бялдрын түвшинг зориулалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хэмжиж, иргэдэд зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлэх сорилын төвийг байгуулах.	2023 VI/1-31	Ажлын хэсгийн гишүүд
15.	Сорилын талаар сургалтыг үе шаттай зохион байгуулах	2023 IV/3-21, VIII/15-25	Н.Батмагнай
16.	Сорилын төвийн үйл ажиллагаа иргэд, нийтэд суртчилан таниулах, ач холбогдлыг суртчилах.	2023 V/15-XI/30	Ажлын хэсэг



Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир,
спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 01 дүгээр
сарын... – ны өдрийн... дугаар тушаалын Гуравдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

- 1.1 “Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх”, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Эрүүл идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.” гэсэн зорилтуудыг тусгасан байдаг. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгай багаж хэрэглэлээр тоноглогдсон байнгын ажиллагаатай сорилын төв байгуулахаар болсон. Сорилын бүртгэл, дасгалын жор, үнэлгээний үр дүнг цахим хэлбэрт оруулах, нэгдгэх зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн. Мөн сорилын төвийн үйл ажиллагаатай холбоотойгоор бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэх шаардлагатай болсон.

Хоёр. Зорилго

- 2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.3, 10.1.8, 10.1.10 – т заасныг хэрэгжүүлэх хүрээнд бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэх, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг эрхлэх, зөвлөгөө өгөх, биеийн тамирын үйлчилгээ үзүүлэх сорилын төв байгуулах замаар идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир спортын ээлтэй орчныг бүрдүүлэх нь уг ажлын гол зорилго юм.

Гурав. Зорилт

- 3.1 Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэх, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг эрхлэх, зөвлөгөө өгөх, биеийн тамирын үйлчилгээ үзүүлэх сорилын төв байгуулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.
 - 3.1.1 Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэн батлуулах;
 - 3.1.2 Хүн амын хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан тоног төхөөрөмж бүхий иргэдийн бие бялдрын түвшинг тодорхойлж, үйлчилгээ үзүүлэх сорилын төв байгуулах;
 - 3.1.3 Батлагдсан стандартын дагуу бие бялдрын түвшин тогтоох сорилын үйлчилгээний мэдээллийг цахим санд хадгалах, өгөгдлийг ашиглах;

- 3.1.4 Сорилын талаарх ажил үйлчилгээг иргэдэд сурталчлах, арга зүйчдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, иргэдийн нас, хүйс, бие бялдрын онцлогт тохирсон дасгалын жор боловсруулах үйл ажиллагаанд санал, зөвлөмж хүргүүлэх;

Дөрөв. Зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлууд

- 4.1 Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэн батлуулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.
- 4.1.1 Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг боловсруулахад шаардагдах мэдээллийг нэгтгэж дүгнэх;
- 4.1.2. Эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн санал, зөвлөмжийг стандартад тусгах;
- 4.2 Хүн амын хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин цагийн үеийн дэвшилтэд технологид суурилсан тоног төхөөрөмж бүхий иргэдийн бие бялдрын түвшин тодорхойлж, үйлчилгээ үзүүлэх сорилын төв байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ;
- 4.2.1 Сорилын төвд шаардагдах тоног төхөөрөмж, хэрэглэл материалын судалгааг гаргаж, сорилын төвийн зай талбайн хэмжээг тодорхойлох;
- 4.2.2 Сорилын төвд ажиллах боловсон хүчин, хүний нөөцийн бодлогыг салбарын мэргэжилтнүүдийн нөөцийн судалгаанд тулгуурлан боловсруулах;
- 4.2.3 Сорилын төвийн үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтыг боловсруулж батлуулах;
- 4.3 Батлагдсан стандартын дагуу бие бялдрын түвшин тогтоох сорилын үйлчилгээний мэдээллийг цахим санд хадгалах, өгөгдлийг ашиглах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлнэ;
- 4.3.1 Батлагдсан стандартын дагуу бие бялдрын сорилын мэдээллийн системд холбогдох өөрчлөлтийг хийх процесс болон өгөгдлийн сангийн архитектурын зураглалын боловсруулах ажлыг ажил хариуцсан албан хаагчдыг хамруулан зохион байгуулах.
- 4.3.2 Боловсруулсан процессын зураглал болон өгөгдлийн сангийн архитектурын зураглалын цахим сангийн хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх.
- 4.3.3 Сорилын цахим санг бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэх.
- 4.3.4 Сорилын үр дүнгээс хамаарч иргэдэд шаардлагатай (мэргэжлийн талуудын оролцоотойгоор бэлтгэн бэлэн болсон мэдээллийн сангаас шууд ашиглах нөхцөлөөр) мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргүүлэхэд цахим санг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.
- 4.4 Сорилын талаарх ажил үйлчилгээг иргэдэд сурталчлах, арга зүйчдийг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, иргэдийн нас, хүйс, бие бялдрын онцлогт тохирсон дасгалын жор боловсруулах үйл ажиллагаанд санал, зөвлөмж хүргүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлнэ;

- 4.4.1 Сорилын төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах.
- 4.4.2 Сорилын төвийн үйл ажиллагааг эрхлэх арга зүйчдийг үе шаттай сургах, дадлагажуулах.
- 4.4.3 Бие бялдрын түвшин тогтоох сорилын шалгуур үзүүлэлт, арга, аргачлалыг баталж, гарын авлага зөвлөмж

Тав. Зохион байгуулах хугацаа.

- 5.1 Бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг шинэчлэх, сорилын төв байгуулах ажлыг 2023 оны 1 сарын 15-наас 2023 оны 10 дугаар сарын 31- ний өдрүүдэд хийж хэрэгжүүлнэ.

Зургаа. Удирдлага зохион байгуулалт.

- 6.1 Ажлын хэсгийн дарга нь ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулж, хурлаас гарсан шийдвэрийг Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга нарыг мэдээллээр хангаж ажлын хэсгийн гишүүдийг удирдлага арга зүй, ажиллах нөхцөлөөр хангаж ажиллана.
- 6.2 Ажлын хэсгийн гишүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрт ноогдсон ажлыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэн ажлын хэсгийн хуралд тайлагнаж, хурлаас гарах аливаа шийдвэрт санал бодлоо илэрхийлэх, тусгах бөгөөд хурлын шийдвэрийг эцэслэхдээ холбогдох хууль, дүрмийн дагуу шинжлэх ухаанч, бодит судалгаа дүгнэлтэд үндэслэн олонхын байр суурийг тусган гаргана.

Долоо. Хүлээгдэж буй үр дүн

- 7.1 Сорилын төв нь хүний биометрийн үзүүлэлт болон бие бялдрын түвшинг зориулалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хэмжиж, сорилын үнэлгээнд суурилсан хувь хүнд тохирсон дасгалын жор, зааврын дагуу зөвлөгөө өгөх, бие бялдрын түвшин доогуур иргэдэд чиглэсэн биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг зааж, чиглүүлэн үйлчилгээ үзүүлдэг болох юм.
- 7.2 Сорилын төвтэй болсноор иргэдийн биометрийн үзүүлэлт болон бие бялдрын чанаруудыг хэмжиж гарсан үр дүнд тулгуурлан үйл ажиллагааг эрхлэх нийтийн биеийн тамирын шинэ үйлчилгээ нэвтэрнэ.
- 7.3 Иргэд сорилын үр дүнтэй холбоотойгоор өөрт шаардлагатай мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг цахим сангаар дамжуулан ашиглах нөхцөл бүрдэнэ.
- 7.4 Иргэдийн нас, хүйс, харьяалал зэрэг мэдээллийг агуулсан бие бялдрын сорилын үзүүлэлт бүхий үндэсний хэмжээний дата сан бүрдэнэ. Уг сан бий болсноор нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох мэдээллийн бодит эх сурвалжтай болно.

Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир,
спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 01 дүгээр
сарын 27-ны өдрийн 4 дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Тус ажлын хэсэг нь Монгол улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын баталсан бүрэлдэхүүнээр үйл ажиллагаагаа явуулна.

Нэг. Нийтлэг журам

1. Ажлын хэсгийн шийдвэр гаргах үйл ажиллагаа хуралдаан байна.
2. Хурлыг гишүүдийн 50-с доошгүй хувийн бүрэлдэхүүнтэй хийнэ.
3. Цаг үеийн тулгамдсан асуудал шийдвэрлэх шаардлагатай асуудлаар тухай бүр ажлын хэсгийн дарга хурлыг зарлан хуралдуулж болно.
4. Ажлын хэсгийн дарга эзгүйд чухал хэрэгтэй бол нарийн бичиг удирдан явуулж болно. Хэлэлцэж буй асуудлаар хорооны гишүүдийн олонхын саналыг үндэслэн эцсийн дүгнэлт хийж, хурлын шийдвэр, тогтоол, тэмдэглэл гаргана.
5. Хуралдааныг цахим болон танхим гэсэн хэлбэрээр зохиож болно.
6. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн даргаар хянуулж гарын үсэг зурж баталгаажуулна.
7. Хурлаар хэлэлцэх асуудлыг нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан тарааж танилцуулан бэлтгэлийг хангана.
8. Гишүүдийн ажлын хуваарь:
 - Удирдлага зохион байгуулалт (О.Баасан)
 - Төлөвлөлт, боловсруулалт (Н.Батмагнай, Б.Ганцэцэг)
 - Зөвлөмж, дүгнэлт Хэлэлцүүлэг (А.Болдмаа С.Мөнх-Эрдэнэ)
 - Хурал, уулзалт (Н.Батмагнай, Б.Ганцэцэг)

Гишүүд энэхүү ажлын чиглэлийн хуваарийн дагуу төлөвлөгөөнд заагдсан ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Ажлын хэсгийн гишүүдийн ажлын хуваарь

1. Дарга:
 - Үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
 - Үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийн явц, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих
 - Ажлын хэсгийн хурал зарлах, хуралдуулах, шийдвэрлэх,
 - Ажлын хэсгийн үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх
2. Ажлын хэсгийн гишүүд:
 - Хариуцсан ажил, үүргийг цаг тухайд нь хийх, зохион байгуулан гүйцэтгэх
 - Ажлыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай ажиллах,
 - Ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцон тусалж, дэмжих
 - Төлөвлөлт, боловсруулалтад хамтран ажиллах
3. Нарийн бичгийн дарга:
 - Ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлэх,
 - Ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна,
 - Ажлын хэсгийн гишүүдийг зайлшгүй мэдээллээр хангана,
 - Бичиг баримт, түүний боловсруулалтыг хийнэ,